



“МОНГОЛ ЦАМХАГ ШАТ” ХХК -ИЙН
ЗАХИРАЛ Э.БАТХҮҮ



“ДЦС-2” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ С.БЯМБААХҮҮ

ИНДУСОФТ ВЕБ СТУДИО ПРОГРАММ ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2019 оны 02 -р сарын 18 -ны өдөр

№ А-19/18

Улаанбаатар хот

Нэг талаас “ДЦС-2” ТӨХК (цаашид “Худалдан авагч” гэх)-ийг төлөөлж Хангамж үйлчилгээ хариуцсан дэд захирал Г.Болдсайхан, нөгөө талаас “Монгол цамхаг шат” ХХК (цаашид “Худалдагч” гэх)-ийг төлөөлж захирал Э.Батхүү нар “Иргэний хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” -ийг үндэслэн доорх нөхцөлөөр харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Худалдагч нь энэхүү гэрээний хавсралт №1-д заасан индусофт 8.1 веб студио программ (цаашид “Бараа гэх) нийлүүлж, Худалдан авагч нь барааг хүлээн авч гэрээнд заагдсан барааны үнийг төлөх болон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

Хоёр. Гэрээний үнэ, төлбөр тооцоо

- 2.1 Гэрээний үнэ 2,350,000 /хоёр сая гурван зуун тавин манга/ төгрөг байх бөгөөд НӨАТ тооцсон үнэ байна.
- 2.2 Худалдан авагч нь урьдчилгаа төлөхгүй ба төлбөрийг бараа хүлээлгэн өгч гэрээ дүгнэсэн акт үйлдсэний дараа 10 хоногт багтаан төлж барагдуулна.
- 2.3 Худалдан авагч нь барааг дагалдах бичиг баримтыг үндэслэн хүлээн авч орлогод авна.

Гурав. Бараа нийлүүлэлтийн чанар, баталгаа, хугацаа

- 3.1 Худалдагч нь барааг энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 хоногийн дотор худалдан авагчид нийлүүлж хүлээлгэж өгнө.
- 3.2 Худалдан авагч талын комисс барааг захиалсан марк, чанар, стандартын шаардлага тохирч буй эсэхийг шалгаж хүлээн авах ба шаардлага хангахгүй нь тогтоогдсон тохиолдолд худалдагч талд барааг буцаана.
- 3.3 Худалдагчийн буруугаас шалтгаалаагүй давагдашгүй нөхцөл байдлын улмаас барааг хугацаандаа нийлүүлээгүй бол худалдагч тал аливаа хариуцлага хүлээхгүй.

